

“Монголросцветмет” ТӨҮГ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

“Монголросцветмет” ТӨҮГ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.4 заалтыг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор геологи хайгуул, уул уурхай, байгаль орчин, эрчим хүч, авто тээвэр, инженер механик, барилга, худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах саналыг хүргүүлж байна.

А. Хамтран ажиллах байгууллага, төлөөлөлд тавигдах шалгуур:

1. Сүүлийн 5 жилийн хугацаанд Төрийн худалдан авах ажиллагаанд 2-оос доошгүй жил оролцож, мөн 2-оос доошгүй захиалагч байгууллагатай гэрээгээр хамтран ажилласан байх,

2. Байгууллагаас тендерийн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах боломжтой, дээрхсалбаруудад багтсан 3-аас доошгүй салбарын 10-аас доошгүй мэргэшсэн төлөөлөл /гишүүн/-тэй байх,

3. Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах төлөөлөл нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.3, 47.6 дахь заалтуудын шаардлагыг хангасан байх.

Б. Ирүүлэх материал:

1. Хамтран ажиллах тухай хүсэлт

2. Байгууллагын танилцуулга, хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм

3. Төрийн худалдан авах ажиллагаанд оролцож байсныг нотлох гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсвэл хамтран ажиллаж байсан газрын тодорхойлолт

4. Тендерийн үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулахаар санал болгож буй гишүүдийн анкет, иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом, АЗ сертификатын хуулбарууд.

Хамтран ажиллах тухай хүсэлтийг холбогдох материалын хамт 2023 оны 11 дүгээр сарын 24-ний 15.00 цагаас өмнө доорхи хаягаар хүлээн авна.

Монгол улс, 13341, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,

Энхтайваны өргөн чөлөө-98, “Монголросцветмет” ТӨҮГ

өрөө/утас: 409 тоот өрөө, утас: 450060+188

и-мэйл: mailbox@monros.mn